



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/356

Мөрөн

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "г" заалт, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мөрөн сумын иргэн Д.Амаржаргал, Б.Мишка, Д.Мөнх-Очир, М.Намжилмаа, П.Бямбасүрэн, Л.Буянбадрах нарт тус бүрт амьдралын хүнд байдал, эрүүл мэндийн шалтгааныг харгалзан 30000 төгрөгийн тусламж, "Хөвсгөл" ТВ-д 300000 төгрөг, Эрх чөлөө сонины төлбөрт мэдээллийн зардалд 300000 төгрөг, Ахмадын баярыг тохиолдуулан "Нутгаа дуулья" тоглолтыг 300 ахмадуудад үзүүлэхэд 1.500.000 төгрөгийн дэмжлэг зэргийг зарцуулсугай.

2. Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-т түймрийн зардалд 1180300 төгрөг, Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-т түймрийн зардалд 7905930 төгрөг, боом өвчний хохиролд 7578527 төгрөг, Цагааннуур сумын ЗДТГ-т түймрийн зардалд 4137950 төгрөг, Мөрөн сумын ЗДТГ-т үерийн зардал хохирлыг арилгахад 10826000 төгрөг, Онцгой байдлын хэлтэст ой хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ажилласан шатахууны зардалд 1425600 төгрөг, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт малын боом өвчний үед ажилласан зардалд 3291500 төгрөг, нийт 28439877 төгрөгийг зарцуулсугай.

3. Шаардагдах 38225807 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Зарцуулалтын тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын ня-бо Ц.Нармандахад ирүүлэхийг холбогдох байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР